УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

ПАРЛАМЕНТЫН
СУДАЛГАА
ХӨГЖЛИЙН
ХҮРЭЭЛЭН

ШҮҮХ, ШҮҮГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Харьцуулсан судалгаа
Судалгааны код: СТ-24/212

2024.10.04

Захиалагч:	УИХ-ын гишүүн Д.Цогтбаатар
Хянасан:	Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн захирал Д.Бумдарь
Судалгаа удирдсан:	ПСХХ-ийн хэлтсийн дарга (PhD) Ц.Норовдондог
Судлаачид:	Э.Дашзэгвэ, И.Жаргалзаяабямба, Ц.Ариунаа, Б.Мөнгөнсувд

УЛААНБААТАР
2024 ОН

АГУУЛГА

УДИРТГАЛ …….. 3

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ……. 4

НЭГ. ШҮҮХ, ШҮҮГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ 6

ХОЁР. ШҮҮХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ БҮТЭЦ ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА……..... 9

2.1. Америкийн нэгдсэн Улс (АНУ) ……..…….….. 9

2.2. Австралийн Холбооны Улс (АХУ)……..……..... 14

2.3.Холбооны Бүгд Найрамдах Герман Улс…… 16

ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ШҮҮХ, ШҮҮГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТОГТОЛЦОО, ҮЙЛ АЖИЛЛАГАА…….…….... 20

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ ……..…….…….. 24

Хавсралт…… 27

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АХУ	Австралийн Холбооны Улс
ЕХ	Европын Холбоо
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
НУМА	Америкийн Нэгдсэн Улсын Маршалын Алба

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын захиалгын дагуу “Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны талаарх харьцуулсан судалгаа”-г Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, хэрэгжүүлэх тогтолцооны талаарх Монгол Улсын болон гадаадын зарим орны эрх зүйн орчин, туршлагыг хууль тогтоомж, практик үйл ажиллагааны хүрээнд тоймлон судлах.

Мэдээлэл лавлагааны хамрах хүрээ: Асуудлыг Монгол Улсын болон гадаадын зарим орны эрх зүйн орчны хүрээ, холбогдох хууль тогтоомж, практик үйл ажиллагааны туршлага болон шүүхийн олон улсын байгууллага, судалгааны төв, судлаач, эрдэмтэдийн гаргасан гарын авлага, зөвлөмж болон эрдэм шинжилгээний өгүүлэл, материалын хүрээнд тус тус тоймлон судаллаа.

Мэдээлэл лавлагааны бүтэц: Судалгааны тайлан үндсэн 3 хэсэгтэй. Нэгдүгээр хэсэгт, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангахад тавигдах нөхцөл, шаардлага, Шүүхийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа ба тогтолцооны талаарх үндсэн мэдээлэл, Хоёрдугаар хэсэгт, шүүхийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа ба тогтолцооны талаарх гадаадын зарим орны туршлага, эрх зүйн орчны талаарх Гуравдугаар хэсэгт, Монгол Улс дахь шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах бүтэц, үйл ажиллагаа, тулгамдсан асуудлуудын талаарх мэдээллийг тус тус оруулсан болно.

Түлхүүр үг: *Аюулгүй байдал, шүүхийн аюулгүй байдал, шүүгчийн аюулгүй байдал,*

Key words: *Security, Court Security, Judicial Safety*

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Хууль дээдлэх ёс (Rule of Law)-ны үндсэн баталгаа нь шүүхийн хууль ёсны , шударга шийдвэр юм. Шүүхээс зөв, шударга шийдвэр гаргах, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахад нөлөөлдөг гол хүчин зүйлсийн нэг нь шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах тухай асуудал байдаг.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдал (Court security, Judicial safety) гэдэг нь шүүхийн барилга байгууламж, түүний доторх, гаднах дэд бүтэц болон албан үүргээ гүйцэтгэж буй шүүгч, шүүх бүрэлдэхүүн, бусад ажилтан, албан хаагчид, шүүх хуралдаанд оролцогчдыг заналхийлэл, айлган сүрдүүлэлт, гэм хор учруулахаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, шүүх хуралдааны дэг журам сахиулахад чиглэсэн цогц арга хэмжээ, дүрэм журам, бүтэц тогтолцооны хүрээгээр тодорхойлогдоно. Олон улсад АНУ-ын Шүүхийн Үндэсний төв (National Center for State court)-өөс гаргасан “Шүүхийн аюулгүй байдлын гарын авлага”-д дурдсан шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой 10 асуудлыг нийтлэг байдлаар хүлээн зөвшөөрч дэмждэг байна.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг шүүх өөрөө дангаараа хангалттай хэмжээнд хэрэгжүүлэх боломж хомс, үндсэн чиг үүргийнхээ хүрээнд ч тийм чадавх, нөөц бүрдүүлэх боломжгүй байдаг байна. Иймд улс орнууд шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор шүүхэд дэмжин туслах чиг үүрэгтэй байгууллага, албан тушаалтнуудыг татан оролцуулж, үүнд чиглэсэн бүтэц, тогтолцоог бүрдүүлдэг байна.

Судалгаанд авагдсан гадаадын зарим орны туршлагаас үзэхэд, шүүх бие даасан, шүүгч хараат бус байхад шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах үүрэгтэй тусгай алба чухал үүрэгтэй байна. Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах нь нэг удаагийн шинжтэй бус, байнгын тогтмол ажиллагаа тул энэ чиг үүргийг хэрэгжүүлж буй тусгай алба нь тодорхой стратегитай, гэмт халдлагын нөхцөл байдалтай уялдуулан шуурхай ажиллах шаардлагатай тулгардаг байна.

Энэ төрлийн байгууллага, албан тушаалтнуудыг нэрлэвэл:

1. Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэгтэй дагнасан байгууллага (АНУ)
2. Шүүхийн захиргааны доторх шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах ажилтан, албан хаагчид (Австрали)
3. Цагдаагийн байгууллагын тусгай нэгж, албан тушаалтан (ХБНГУ, Монгол)

Тухайлбал,

АНУ-ын Маршалын алба *(*US Marshals Service*)* нь шүүхийн тогтолцоо, түүний аюулгүй байдлыг сахин хамгаалах чиг үүрэгтэй агентлаг бөгөөд Хууль зүйн яамандаа харьяалагддаг, Энэ нь 1789 оноос үйл ажиллагаа явуулж байгаа олон жилийн түүхтэй байгууллага юм. Тус алба нь Холбооны Улсын шүүхийн 94 тойргийн 2700 гаруй шүүгч, 30,300 орчим прокурор болон шүүхийн ажилтан, албан хаагчдын аюулгүй байдлыг сахин хамгаалах үүрэгтэй ажилладаг.

Австрали Улсад Шүүхийн захиргааны байгууллагын тэргүүн нь уг асуудлыг хариуцсан шүүхийн эрх бүхий ажилтан, шүүхийн аюулгүй байдлын ажилтныг томилдог. Шүүхийн аюулгүй байдлын ажилтан, эрх бүхий шүүхийн ажилтан нь чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд зохих сургалтад хамрагдаж, тусгай зөвшөөрөл авсан байх шаардлага тавигддаг.

ХБНГУ-д шүүхийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэд хэдэн субьектууд хэрэгжүүлдэг байна. Тухайлбал, шүүх, цагдаа, шүүхийн аюулгүй байдлын тусгай ажилтнууд гэх мэт. ХБНГУ-ын муж улс бүр шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг өөрсдийн хууль, эрх зүйн орчны хүрээнд хангаж ажилладаг. Ялангуяа муж улсын түвшинд цагдаагийн байгууллага голлох үүрэг, оролцоотой ажилладаг байна.

Монгол Улсад 1924 оноос буюу “Шүүн таслах газар”, “Ардын шүүх” зэрэг шүүх байгууллага байгуулагдсан цаг үеэс эхлэн тухайн үеийн цагдан сэргийлэх байгууллагууд (орчин үеийн цагдаагийн алба) шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах, хамгаалах, чиг үүрэгтэй ажиллаж ирсэн.

2013 онд Монгол Улсын Их Хурлаас “Тахарын албаны тухай” хуулийг баталж, Тахарын ерөнхий газар байгуулан шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг тус байгууллагад дагнан хариуцуулсан байдаг. Энэ алба 2016 он хүртэл 2 жил гаруй ажиллаад татан буугдаж, чиг үүргийг нь цагдаагийн албанд буцаан шилжүүлсэн байдаг. Одоогийн байдлаар Цагдаагийн ерөнхий газрын бүтцэд “Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэлтэс”, Нийслэлийн хэмжээнд Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэлтэс төвийн 6 дүүргийг хариуцан 93 албан хаагчийн орон тоотойгоор ажиллаж байна. Түүнчлэн аймгуудын цагдаагийн газрын нийтийн хэв журам хамгаалах тасгийн бүтцэд нөхцөл байдалд уялдуулан орон тоог тогтоож, хариуцсан ажилтныг томилон ажиллуулж байна. 2022 оны байдлаар Цагдаагийн байгууллагад шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй нийт 280 гаруй албан хаагч ажиллаж байсан.

Монгол Улсын шүүхийн тухай хууль (Шинэчилсэн найруулга) 2021 оны 03 сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Уг хуульд шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой шинэлэг зохицуулалтууд нэмэгдсэн нь шүүгч, түүний гэр бүлийн гишүүний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн зохицуулалтууд болсон.

Сүүлийн үед авлига, албан тушаалын гэмт хэргийн нөхцөл байдал, төр, төрийн албан хаагчдад хандах нийгмийн сэтгэл зүйн сөрөг өөрчлөлтийн улмаас шүүгчийн амь нас, эрүүл мэндэд заналхийлсэн халдлага өсөн нэмэгдэж байна. Цагдаагийн байгууллагад гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах өөрийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээндээ ч санхүү, хүн хүчний хомсдолтой байдаг учраас шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хүч, хэрэгсэл дайчлах боломж хомс байдаг байна.

Өнөөдрийн байдлаар шүүх, шүүхийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр цагдаагийн байгууллагын хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь Тахарын албатай харьцуулахад хамгаалалтын арга хэрэгсэл, хүч нөөц, арга механизмын хувьд харьцангуй сул байгааг шүүгч, шүүхийн байгууллагын ажилтнууд онцлон дурдаж байна.[1]

[1] Шүүгчийн аюулгүй байдал. УДШ-ийн ЗХТ-ийн шүүгч Ц.Цогт

ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

НЭГ.ШҮҮХ, ШҮҮГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Хууль дээдлэх ёс (Rule of Law)-ны үндсэн баталгаа болдог шүүх эрх мэдлийн тогтолцооны суурь зарчим нь - шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахад нөлөөлөх нэг чухал хүчин зүйл бол шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах тухай асуудал юм.

Нэр томьёоны хувьд аюулгүй байдал гэдэг нь хувь хүн, нийгэм, улс орон буюу эсхүл аливаа тогтолцооны тодорхой аюул, занал, хор хөнөөлөөс харьцангуй ангид байх төлөв буюу өөрөөр хэлбэл тэдгээрт учрах эрсдэлийн хамгийн бага түвшнийг илэрхийлдэг өргөн хүрээтэй, олон талт ойлголт юм.[2]

Аюулгүй байдал гэдэгт “аюул”, ”занал”, ”эрсдэл” хэмээх үндсэн ойлголт нэр томьёонууд[3] хэрэглэгддэг. Эдгээр нэр томьёоны утга, агуулга, хэрэглээг танин мэдэх нь шүүхийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг бүрэн дүүрэн ойлгож, ухамсарлахад дөхөм болно.

“Аюул” нь улс, нийгэм, хувь хүн эсхүл ямар нэгэн объект, тогтолцооны бүтэц, үйл ажиллагааг алдагдуулах хүчин зүйлийг бодитой агуулж, цаашид хохирол учруулах, улмаар устгахад чиглэсэн далд орших хүч юм.

“Занал” нь аюул хэмээх ойлголттой төстэй боловч болзошгүй байдлаас бодитоор хэрэгжих шатандаа шилжсэн, нэг этгээдээс нөгөө этгээдэд хохирол учруулахад бэлэн болсон санаархал юм. Өөрөөр хэлбэл аюул нь тодорхой объектод шууд чиглэсэн, түүнийг онилсон хэлбэртэй болмогцоо занал, заналхийлэлд шилждэг бөгөөд энэ нь аюулын үргэлжлэл, хор хохирол учруулах нь илэрхий болсон үеийн үйл ажиллагаа (процесс) юм.”.

“Эрсдэл” гэдгийг “гадаад, дотоод хүчин зүйлсээс үүдэлтэй аливаа аюул заналаас хувь хүн, нийгэм болон төр улсын хамгаалагдсан байдлын түвшнийг үлэмж хэмжээгээр бууруулж болзошгүй тааламжгүй үйл явц (хямралт үйл явдал, элдэв осол сүйрэл, байгалийн гамшиг) болон тэдгээрээс болж учрах хор хохирлын үүсэх магадлалын хослол” хэмээн тодорхойлсон байдаг.[4]

Шүүхийн тухайд аюулгүй байдал (Court security) гэдэг нь шүүхийн барилга байгууламж, түүний доторх болон гаднах дэд бүтэц, албан үүргээ гүйцэтгэж буй шүүгч, шүүх бүрэлдэхүүн, бусад ажилтан, албан хаагчид, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хамгаалах, шүүх хуралдааны дэг журам сахиулахад чиглэсэн арга хэмжээ, журам, тогтолцоог хэлнэ. Эдгээрт шүүхийн үйл ажиллагаанд саад учруулах, шүүхийн ажилтнууд, шүүх бүрэлдэхүүн, өмгөөлөгчид болон олон нийтэд аюул учруулж болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад чиглэсэн олон төрлийн хамгаалалтын арга хэмжээнүүд багтана.

Харин шүүгчийн аюулгүй байдал (Judicial safety) гэдэг нь шүүгч, шүүгчид болон шүүхийн бусад ажилтнуудыг мэргэжлийн үүргээсээ шалтгаалж заналхийлэл, айлган сүрдүүлэл, хор хохирол учруулахаас хамгаалахыг хэлнэ. Үүнд шүүгч, шүүхийн

[2] Монгол Улсын үндэсний аюулгүй байдал (онол, практикийн асуудлууд) 2022 УБ, 13 дахь тал
[3] Монгол Улсын үндэсний аюулгүй байдал (онол, практикийн асуудлууд) 2022 УБ, 17-19 дэх тал
[4] Монгол Улсын үндэсний аюулгүй байдал (онол, практикийн асуудлууд) 2022 УБ, 18 дахь тал

ажилтнуудын бие бялдар, сэтгэл зүйн аюулгүй байдлыг хангах, шүүх хуралдааны танхимд болон гадна орчинд биечилсэн хамгаалалтын арга хэмжээнүүд багтана.

АНУ болон олон улсын хэмжээнд 2001 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн террорист халдлагын дараагаар шүүх, шүүгчийн аюулгүй байдлын асуудлыг онцгойлон анхаарч ирсэн. Үүнтэй холбоотойгоор АНУ-ын Шүүхийн Үндэсний төвөөс гаргасан Шүүхийн аюулгүй байдлын гарын авлагад шинжээчид шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой дараах үндсэн 10 хүчин зүйлсийг тодорхойлсон байдаг.[5] Үүнд:

1) Үйл ажиллагааны аюулгүй байдал: Шүүхийн аюулгүй байдлыг хангахын тулд аюулгүй ажиллагааны стандарт горим, дэг журмыг ягштал мөрдөж хэвшүүлэх шаардлагатай байдаг;
2) Барилга, байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөлт: Одоо байгаа шүүхийн барилга, байгууламжийн өөрийн үнэлгээг хийж, тухайн шүүхийн байр, танхимын давуу, сул талыг үнэлсний үндсэн дээр дотор нь байгаа хүмүүсийг хамгийн үр дүнтэй хамгаалах төлөвлөлт хийдэг;
3) Онц байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээ: Шүүхийн байр, шүүгчид байгалийн болон хүний хүчин зүйлсээс шалтгаалсан гамшигт байдал, аюул, эрсдэлд хэзээ ч орж болзошгүй юм. Энэ тохиолдолд үйл ажиллагаагаа хэвийн, жигд үргэлжлүүлэхийн тулд яаралтай хариу арга хэмжээ авах баг, бүрэлдэхүүн, тэдгээрийн гүйцэтгэх үүрэг, оролцоо, харилцаа холбооны хуваарь зэргийг тодорхойлсон журам бэлэн байх ёстой;
4) Гамшгийн үед хэрэгжүүлэх нөхөн сэргээх арга хэмжээ: Жишээлбэл, гамшиг, онц байдлын үед үрэгдсэн, эсхүл гэмтсэн цахим болон хэвлэмэл материалуудыг хэрхэн нөхөн сэргээх талаар нөөц төлөвлөгөө гаргах шаардлагатай;
5) Аюул, эрсдэлийн үнэлгээ: Аюул, эрсдэлийг үнэлэх журам боловсруулж, шүүхүүдийн аюул, эрсдэлийн байдалд үнэлгээ хийн ноцтой аюул, заналыг илрүүлж, улмаар урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, бууруулах арга хэмжээ авдаг;
6) Осол, аюулыг тайлагнах: Тухайн шүүхэд гарсан сэжигтэй болон ноцтой тохиолдлыг мэдээлэх, тайлагнах албан маягтын загвар болон журам батлаж мөрдүүлдэг;
7) Санхүүжилт: Шүүхийн аюулгүй байдлыг хангах хүний нөөц, техник, тоног төхөөрөмж бэлтгэхэд хангалттай төсөв шаардагддаг;
8) Аюулгүй байдлын тоног төхөөрөмжийн бүртгэл: Шүүхүүдэд аюулгүй байдлыг хангах ямар техник, тоног төхөөрөмж, хэрэгсэл байгаа, тэдгээрийн үнэ, үйлдвэрлэгдсэн, засварласан огноо, хүчин чадал, зэргийг тусгасан бүртгэл хөтлөх шаардлагатай;
9) Хүний нөөц, хамтын ажиллагаа: Шүүхийн аюулгүй байдлыг хангахын тулд холбогдох хууль сахиулах байгууллага, албадтай нягт хамтран ажиллах шаардлагатай байдаг;
10) Шүүхийн шинэ байрны зураг төсөл төлөвлөх: Шүүхийн барилга, байгууламжид анх зураг төслийг боловсруулахдаа л аюулгүй байдлын нөхцөл, шаардлагыг тусгах шаардлагатай.

Судлаачид шүүх, шүүгчийн аюулгүй байдал ба шүүн таслах үйл ажиллагааны харилцан уялдааны асуудлыг дэвшүүлсэн байдаг. Ингэхдээ шүүх, шүүгчийн аюулгүй

[5] CCJ/COSCA Court Security Handbook: Ten Essential Elements for Court Security and Emergency Preparedness. National Center for State court

байдлыг хангах ба шүүн таслах үйл ажиллагааны нээлттэй байдал нь харилцан тэнцвэртэй байх шаардлагатай гэж тэмдэглэсэн байна. Монгол Улсын Шүүхийн тухай хуульд зааснаар шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй, ил тод байна. Мөн шүүх хуралдааныг хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд нээлттэй явуулна гэж заасан. Гэтэл энэ нь иргэд шүүхэд чөлөөтэй нэвтрэх нөхцөл болох төдийгүй шүүн таслах үйл ажиллагаа хэвийн явагдахад бэрхшээл учруулах нэг хүчин зүйл болдог байна.

Шүүх өөрөө шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг дангаараа амжилттай хангах боломжгүй төдийгүй тийм чадавх, нөөцгүй болохыг судалгааны бүтээлд тэмдэглэсэн байдаг. Иймд шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангахад шүүхэд дэмжин туслах чиг үүрэг бүхий тусгай байгууллага, албан тушаалтны нэгдлийг шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах бүтэц тогтолцоо гэж ойлгоно. Шүүхийн аюулгүй байдал нэг удаагийн зорилго, хүрэх цэг биш, харин байнгын анхаарал тавих зайлшгүй шаардлагатай тасралтгүй процесс байх ёстой бөгөөд нийт хууль сахиулах байгууллагын хүчин чармайлтын үндсэн дээр тогтдог.[6]

Ийм бүтэц тогтолцоо нь орон нутгийн түвшинд, бүсийн түвшинд, үндэсний түвшинд төдийгүй олон улсын түвшинд хамтран ажиллах чадавх, нөөцтэй байх шаардлагыг бий болгоно гэж зарим судлаач тэмдэглэжээ. Энэ хүрээнд шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах бүтцэд тусгай чиг үүрэгтэй бие даасан байгууллага, цагдаагийн байгууллага, нутгийн захиргааны байгууллага, хуульчдын холбоог хамааруулах бөгөөд үүнээс тусгай чиг үүрэгтэй бие даасан байгууллага нь голлох үүрэгтэй, үндсэн бүтцэд хамаарна.

Олон улсын хэмжээнд онц ноцтой гэмт хэргүүдийг үр дүнтэй шийдвэрлэх чадамжтай бие даасан шүүх, хараат бус шүүгчийн үйл ажиллагааны гол хүчин зүйл нь шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх тусгай албад гэж үздэг байна. Үүнд ОХУ-ын Холбооны Шүүхийн дэргэдэх хууль сахиулах алба, Францын Үндэсний Жандармерын алба, Канадын Шерифийн алба, АНУ-ын Маршалын албыг тус тус нэрлэж болно. Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах нь нэг удаагийн шинжтэй бус, байнгын тогтмол үйл ажиллагаа тул энэ чиг үүргийг хэрэгжүүлэх тусгай алба нь тодорхой стратегитай, гэмт халдлагын нөхцөл байдалтай уялдаж шуурхай ажиллах чадамжтай байхыг шаарддаг. Жишээ нь, АНУ-ын Маршалын алба өөрийн гэсэн стратеги төлөвлөгөөтэй бөгөөд 2020-2024 оны стратеги төлөвлөгөөндөө цаг үеийн хурдтай өөрчлөлтөд хэрхэн зохицож ажиллах, бэлэн байдлыг хангах асуудалд онцгой анхаарал хандуулсан байдаг.

[6] Шүүхийн аюулгүй байдлыг хангах бүтэц, түүнийг цаашид бэхжүүлэх арга зам. ШСМСХ-ийн судлаач Л.Галбаатар, ахлах референт Э.Өлзийлхам (PhD), Судалгааны тайлангийн эмхэтгэл, Шүүхийн судалгаа мэдээлэл, сургалтын хүрээлэн 2016, 57 дахь тал

ХОЁР. ШҮҮХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ БҮТЭЦ ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

2.1.АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС


Шүүхийн аюулгүй байдлыг хангах бүтэц, тогтолцоо

Шүүхийн аюулгүй байдлыг хангах[7] чиг үүрэг бүхий Нэгдсэн Улсын Маршалын алба (US Marshals Service) нь шүүхийн тогтолцоо, түүний аюулгүй байдлыг сахин хамгаалах агентлаг бөгөөд Хууль зүй яаманд харьяалагдана. Нэгдсэн Улсын Маршалын Алба (НУМА) нь 1789 оны 9 дүгээр сарын 24-ны өдөр Конгрессоос “Шүүхийн тухай хууль”-ийг баталснаар байгуулагдсан олон жилийн түүхтэй байгууллага юм.

НУМА-ны зорилго[8] нь холбооны шүүх тогтолцоо, түүний аюулгүй байдлыг сахин хамгаалах, шүүхийн байр болон шүүгчид, түүний гэр бүлийн аюулгүй байдлыг хангах замаар холбооны шударга ёсны тогтолцоонд дэмжлэг үзүүлэх, холбооны сэжигтнийг олох, баривчлах, оргон зайлсан ажиллагааг удирдах, хоригдлыг цагдан хорих, тээвэрлэх үед аюулгүй байдлыг хангах, холбооны шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, хууль бусаар олж авсан эд хөрөнгийг илрүүлэх, хураан авах, хураан авсан хөрөнгийг үр дүнтэй удирдах, захиран зарцуулах, хяналт тавих, эрсдэл ихтэй засгийн газрын гэрчийг хамгаалах зэрэг холбооны холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд оршино.

НУМА нь холбооны шүүхийн 94 тойрог, 2700 гаруй шүүгч, 30,300 орчим холбооны прокурор, шүүхийн албан тушаалтнууд, 3,752 гаруй дэд маршал, эрүүгийн мөрдөн байцаагч нарын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх бөгөөд тэдгээрийн аюулгүй байдлыг хамгаалах чиг үүрэгтэй. НУМА-ны бүтцийг дараах зургаар хавсаргав.

Зураг 1. АНУ-ын Маршалын албаны бүтэц



Эх сурвалж:АНУ-ын Маршалын албаны засгийн газрын вэб хаяг
https://www.usmarshals.gov/sites/default/files/media/document/PUB-1-2020-Strategic%20Plan.pdf

[7] *https://www.usmarshals.gov/what-we-do/judicial-security*
[8] *https://www.usmarshals.gov/who-we-are*

НУМА-наас 2020-2024 оны стратегийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байгаа бөгөөд [9] түүндээ цаг үеийн хурдтай өөрчлөлтөд бэлэн байхыг онцгойлон анхаарсан байдаг. Стратеги төлөвлөгөөнд ажиллах хүчинд хөрөнгө оруулалт хийх, мөрдөн шалгах үйл ажиллагааг бэхжүүлэх, аюулгүй байдлын инновацыг хөгжүүлэх, учирч болзошгүй аюулаас хамгаалах, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, технологийн дэд бүтцийг шинэчлэх, нотолгоонд суурилсан өгөгдөл дата боловсруулах, үр дүнтэй, үр ашигтай сайн засаглалыг дэмжих, хөрөнгийг зөв удирдах, мэдлэгээ түгээх, олон нийтийн харилцаа холбоо болон мөрдөн байцаалтын чадавхыг сайжруулах зэрэг олон асуудлуудыг дэвшүүлсэн байна.

Тус алба нь шүүхийн аюулгүй байдалтай холбоотой дараах зарим хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг байна. Үүнд:

- Шүүхийн аюулгүй байдлын ажилтны хөтөлбөр;
- Хамгаалах үйлчилгээний хөтөлбөр;
- Хөрөнгө хураах хөтөлбөр;
- Хоригдлыг харгалзан хамгаалах хөтөлбөр;
- Амиа хорлохоос урьдчилан сэргийлэх хөтөлбөр;
- Шүүхээс оргон зайлсан сэжигтнийг эрэн хайх хөтөлбөр;
- Гэрчийн аюулгүй байдлыг хамгаалах хөтөлбөр;
- Ажилтны камер хөтөлбөр;
- Олон улсын ялтан шилжүүлэх хөтөлбөр.

Эрх зүйн орчин

Мөрдөгдөж буй хууль тогтоомжууд:

- Эрүүгийн хууль (*Criminal Justice Act 18 USA 3006* А)
- Шүүгчийн тухай хууль (*Judges Ac*t)
- Шүүхийн тухай хууль (*H.R 2584-Judiciary Act of 2021*)
- Дээд шүүхийн гэр бүлийн аюулгүй байдлын тухай хууль (*Supreme Court Families Security Act, 2022)*
- Шүүхийн ажилтны ёс зүйн дүрэм *(Code of Conduct for Judicial Employees*)
- Шүүхийн ёс зүй, ил тод байдлын тухай хууль (*Courthouse Ethis and Transparency Act)*
- Шүүхийн танхим дахь камерын бодлого (*Cameras in the Courtroom Policy*)
- Шүүхийн өмнөх мэдээллийн нууцлалын журам (*Confidentiality Regulations for Pretrial Services information*)[10]

Холбогдох байгууллагууд:

- АНУ-ын Шүүгчдийн бага хурал (*Judicial Conference of the United States-JCUS*);
- Шүүхийн аюулгүй байдлын үндэсний төв (*National Center for Judicial Security-NCJS*);
- Шүүхийн аюулгүй байдлын хэлтэс *(Judicial Security Division-JSD*);
- Хамгаалалтын тагнуулын алба (*Office of Protective Intelligence);*
- Хамгаалалтын ажиллагааны алба (*Office of Protective Operations*);

[9] *https://www.usmarshals.gov/sites/default/files/media/document/PUB-1-2020-Strategic%20Plan.pdf*
[10] *https://www.uscourts.gov/rules-policies/judiciary-policies/confidentiality-regulations-pretrial-services-information*

- Улсын шүүхүүдийн үндэсний төв (*National Center for State Court- NCSC;*
- Аюулгүй байдлын хороо (*Security Committtee*).

Нэгдсэн Улсын Шүүгчдийн бага хурал (*Judicial Conference of the United States-JCUS*) нь холбооны шүүхийн тогтолцооны бодлого боловсруулах гол байгууллага юм. Шүүгчдийн бага хурал (*JCUS*)-ыг хоёр жилд нэг удаа зохион байгуулагддаг. Энэ хурлаар Холбооны шүүгчдийн аюулгүй байдлын хөтөлбөрийг дэмжих, Конгрессын санхүүжилтийг нэмэгдүүлэх, шүүгчийн хувийн мэдээлэл, цахим орчны хамгаалалтыг сайжруулах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, шүүгчийн хувийн мэдээллийг олон нийтэд ил нээлттэй болгоход аюулгүй байдлын асуудлаар холбогдох хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх, орон байрны болон шүүхийн барилга байгууламжийн халдлагыг илрүүлэх, хяналтын системийг орчин үеийн аюулгүй, технологийн өндөр шаардлагатай хэрэгслээр шинэчлэлт хийн суурилуулах, засвар үйлчилгээг сайжруулахад Холбооны Хамгаалах Алба (FPS)-д шууд санхүүжилт олгох зэрэг олон асуудлуудыг хэлэлцдэг байна.

Шүүхийн аюулгүй байдлын үндэсний төв (*National Center for Judicial Security-NCJS*) нь хуулийн ёс зүйг дээдлэх бөгөөд үндэсний болон олон улсын хууль сахиулах байгууллага, шүүхийн барилга байгууламжийг хамгаалах, шүүхийн аюулгүй байдалд анхаарах, хамгаалагдсан хувь хүний аюулгүй байдлыг судлан шинжлэх, шүүгчийн гэр бүлийг хамгаалах, сургалт явуулах, хөгжүүлэх, гэнэт халдлагыг илрүүлэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлдэг байна. Түүнчлэн шүүхийн аюулгүй байдлын үйл ажиллагаатай холбоотой хотын захиргаа, хот, муж, холбооны болон олон улсын харьяалалд дэмжлэг үзүүлнэ.

Шүүхийн аюулгүй байдлын хэлтэс [11] (*Judicial Security Division-JSD)* нь: шүүхийн хуралдааны аюулгүй байдлыг хангах, холбооны шүүгч, тангарагтны шүүгч, бусад шүүхийн гишүүдийг хамгаалах, шүүхийн байр, шүүгчийн орон байранд учирч болзошгүй аюулыг урьдчилан сэргийлэн таслан зогсоох, аюул заналын нөхцөл байдлыг тодорхойлох, шүүх хуралдааны бүх үе шатанд хамгийн сүүлийн үеийн хамгаалалтын техник, хэрэгсэл байршуулах, онц байдал, шуурхай хариу арга хэмжээ авах, таслан зогсоохоос гадна шүүхийн үйл ажиллагаанд ажиглалт, эрсдэлээс хамгаалах, аюулгүй байдлаас олон нийтийг хамгаалах үүрэг хүлээдэг. Шүүхийн аюулгүй байдлын хэлтэс нь: 5600 шүүхийн аюулгүй байдлын ажилтнуудтай гэрээ байгуулж, шүүгчийн 1600 гаруй орон сууцанд хамгаалалтын системийг суурилуулж, холбооны 800 гаруй байгууламжийн биет төхөөрөмжийг гэрч, хохирогч, шүүн таслах ажиллагаанд оролцогч нарыг хамгаалах систем, төхөөрөмжийг байршуулж, хэрэгжүүлсэн байна.

Хамгаалалтын тагнуулын алба[12] (*Office of Protective Intelligence)* нь холбооны шүүхийн аюулгүй байдал, хамгаалагдсан ажилтан, барилга байгууламжид аюул занал учруулж болзошгүй хүчин зүйлсийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үйл ажиллагааг судлан, аюулын үнэлгээг удирдах, эрсдэлийг бууруулахын тулд мөрдөн байцаагч, штабын бүрэлдэхүүнд шууд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

[11] *https://www.usmarshals.gov/what-we-do/judicial-security*

[12] *Audit of the U.S.Marshals Service Judicial Security Activities.2021 https://oig.justice.gov/sites/default/files/reports/21-083.pdf*

Хамгаалалтын ажиллагааны алба (*Office of Protective Operations*) нь өндөр түвшний байцаан шийтгэх ажиллагаа, өндөр эрсдэлд суурилсан аюул заналын талаар холбооны 12 шүүхийн бүх тойргийн байгууллагуудад мэргэжлийн мэдлэг, заавар, шууд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. АНУ-ын Маршалын албаны хамгаалалтын үйл ажиллагааны 36 ажилтнаас бүрддэг.

Улсын шүүхүүдийн үндэсний төв (*National Center for State Court-NCSC)* нь шүүх, шударга ёсны тогтолцоонд инновац, технологийн дэвшлийг бий болгоход судлаач, шинжээч, зөвлөхүүдээс бүрдсэн бөгөөд Ерөнхий шүүгчдийн хурал, Улсын шүүхийн захиргааны ажилтны зөвлөгөөн болон шүүхийн удирдах ажилтны бусад холбоодтой хамтран ажилладаг цорын ганц байгууллага юм. Улсын шүүхийн үндэсний төв (*NCSC*)-ийн 2022 онд "Шүүхийн барилга байгууламжийн аюулгүй байдлын сайн туршлага"[13] (*Steps to best practices for Court Building Security*) сэдэвт тайланг гаргажээ[14]. АНУ-д шүүхийн барилга байгууламжийг хянахад учирч болох эрсдэлүүд нэлээд өндөр гардаг бөгөөд байнгын урьдчилан сэргийлэх, хяналтад байлгах асуудал тулгарч байдаг. Шүүхийн барилга байгууламжийн аюулгүй байдал нь харилцан хамаарал бүхий гурван хэсэгтэй. Үүнд:

- Шүүхийн барилга байгууламжийн аюулгүй байдлыг Аюулгүй байдлын хороо (*Security Committee)*-ны бодлого, дүрэм журам, аюул болон ослыг мэдээлэх, аюулгүй байдлын сургалт гэсэн үндсэн дөрвөн зүйлийг авч үздэг бөгөөд тус бүр нь нарийн шат дамжлагатай, бие биеэсээ харилцан хамаарал бүхий үйл ажиллагаа юм.
- Шүүхийн барилга байгууламжийн стандартад байршил, танхим, өрөө, тасалгаа, номын сан, хэргийн оролцогчдын өрөө, иргэд олон нийтэд үйлчлэх өрөө, ажилтнуудын өрөө, орчин нөхцөл зэргийн аюулгүй байдал, харуул хамгаалалтын стандартыг хамруулсан байна.
- Шүүхийн аюулгүй байдлын талаарх үнэлгээг тооцох шалгах хуудсаар шүүгч, шүүхийн ажилтнууд шүүхийн барилга байгууламж дахь олон нийтийн аюулгүй байдлыг хангах талаар 23 төрлийн 200 гаруй асуултад дүгнэлт өгч үнэлгээ хийдэг байна. Энэ үнэлгээгээр цаашид шаардлагатай үйл ажиллагааны дүгнэлт гаргаж, шүүхийн аюулгүй байдлын стандартын дагуу цаашдын төлөвлөгөөг боловсруулдаг байна.

Шүүхийн барилга байгууламжийн аюулгүй байдлын сайн туршлагатай холбоотой бүхий л сэдвүүдийн чухал суурь нь дараах 4 асуудал байдаг. Үүнд:

- Аюулгүй байдлын хороо*.* Шүүхийн барилга байгууламжийн Аюулгүй байдлын хороо нь шүүхийн байрны аюулгүй байдалтай холбоотой асуудлыг шийдэх, хяналт тавих эрх мэдэлтэй байдаг бөгөөд шүүх болон шүүхээр үйлчлүүлэгчдийн үйл ажиллагаанд тулгарч буй аюулгүй байдлын олон асуудлуудыг тодорхойлж, зөвөөр үнэлэн, шийдвэрлэдэг.
- Бодлого болон дүрэм журам*.* Шүүхийн барилга байгууламжийг аюулгүй байлгах баталгааг хангаж, тууштай хэрэгжүүлэхийн тулд аюулгүй байдлын үйл

[13] *https://www.ncsc.org/__data/assets/pdf_file/0032/78647/Best-Practices-for-Court-Building-Security.pdf*
[14] *https://www.ncsc.org/__data/assets/pdf_file/0032/78647/Best-Practices-for-Court-Building-Security.pdf*

ажиллагааны нэгдсэн, цогц бодлого, процедурыг боловсруулах нь байнгын тогтвортой үйл ажиллагаагаар хангана.

- Аюул болон ослыг мэдээлэх. Аюул, ослыг мэдээлэх нь шүүгч, шүүхийн ажилтнууд болон шүүхээр үйлчлүүлж буй олон нийтийн аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой. Болзошгүй сөрөг үйл явдалд шуурхай хариу арга хэмжээ авах, аюулгүй байдлын шилдэг туршлагыг бэхжүүлэх хүрээнд аюул, ослыг мэдээлэх тогтолцоог бий болгоно.
- Аюулгүй байдлын сургалт. Шүүхийн барилга байгууламжид ажиллаж байгаа ажилтнууд аюулгүй байдлын эрсдэл, аюул заналыг анхааран, ажлын байрныхаа аюулгүй байдлыг материаллаг байдлаар хангах боломжтой. Энэ нь үйл ажиллагааг үр дүнтэй ашиглах хамгийн сайн арга бол шүүгчид болон шүүхийн ажилтнуудад аюулгүй байдлын бодлого, журмыг таниулан сурталчлан бэлтгэх үйл явц юм.

Шүүхийн барилга байгууламжийн аюулгүй байдалд хяналтын төв, шүүхийн танхим, шүүгч болон шүүгдэгчийн өрөө, шүүхийн байранд нэвтрэх ажилтан, хяналт тавих төхөөрөмжүүд, нийт шүүхийн байрны үйлчилгээний хэсэг, шүүгчийн машины зогсоол, шүүхийн байрны эргэн тойрон дахь байршилд байнгын хяналт тавих камер суурилуулах, урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг тэмдэглэгээг тавих, хаалгыг байнга түгжээтэй байлгах, тогтмол шалгалт явуулах, халхавч хийж эрсдэлийг багасгах, цахилгаан, агааржуулалтын суваг гэх мэт бүхий л газарт тэсэрч дэлбэрч болохуйц нөхцөлүүдийг судлах, 24 цагийн эргүүлийг тогтмол хийх, нэмэлт хяналтын системийг байршуулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн сайн туршлага болжээ.

Зайлшгүй хэрэгтэй зүйлсэд шүүхийн байранд ажлын цагийн дараа нэвтрэх, онцгой байдлын тоног төхөөрөмж, халдлага илрүүлэх систем, ажлын цагаар дотогш нэвтрэх бүс, нийтийн хүлээлгийн танхим, коридор, цахилгаан шат, шүүхийн төлөөлөгч нарын аюулгүй байдал, эргүүл хийх, бэлэн мөнгөтэй харьцах, захидал болон илгээмж зэрэг сэжиг бүхий зүйлийг шалгах арга хэмжээнүүдийг нарийвчлан тусгасан байна.

Аваарын дохиолол дуугарах үед хамгийн ойрын хяналтын камер ажиллаж эхлэх, бичлэг хийгдэх автомат тохиргоо идэвхэждэг байна. Хяналтын камер нь хүчин чадал сайтай, хөдөлгөөний хязгаарлалтгүй, өнцгийн линзтэй, өнгөт, сүлжээний багтаамж сайтай, видео дүрс дамжуулах, системд нэвтрэх, хянах, сигналтай, бичлэгийг 10-аас доошгүй хоногт хадгалах, бичлэгийн функцийг хөдөлгөөн ба дуу гарахаар эсхүл аваарын дохиолол, халдлага илрүүлэх дохиоллоор идэвхжих хүчин чадалтай байдаг. Тиймээс шүүхийн барилга байгууламжийн сайн туршлагыг хэрэгжүүлсэн нь аюулгүй байдлыг сайжруулсан гэж үзсэн байна.

Шүүхийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны эерэг талууд:

1.НУМА нь холбооны гэрчүүдийн аюулгүй байдлыг хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Энэ хөтөлбөрт зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл, террорист халдлага зэрэг томоохон гэмт хэрэг болон тэдгээрт оролцсон гишүүдийн эсрэг мэдүүлэг өгсөн гэрчүүд хамрагддаг. Хамгаалагдсан гэрчүүдэд эхний ээлжинд орон сууцны болон бие даах чадвартай болох хүртэл санхүүгийн дэмжлэг үзүүлдэг байна. Гэрчийг хамгаалах хөтөлбөрийг АНУ-ын Засгийн газар зохион байгуулалттай гэмт

хэрэг, хар тамхины наймаа, терроризм болон бусад томоохон гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал ач холбогдолтой, үр дүн нь эерэг үзүүлэлттэй байна гэж дүгнэжээ[15].

2.Конгрессын Гэмт хэргийн хяналтын иж бүрэн хууль баталснаар гэмт хэрэг үйлдсэн этгээдээс хөрөнгө хураах хөтөлбөрийг бий болгосон. НУМА нь гэмт хэргээс олсон орлогыг ашгийн бус байгууллагад шилжүүлэх, хар тамхи, мансуурах бодист донтогсдыг эмчлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сургалт явуулах, орон байр, ажлын ур чадвар, олон нийтэд түшиглэсэн нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдлын бусад хөтөлбөрийг дэмжих зорилгоор үл хөдлөх хөрөнгө (*худалдах, борлуулах г.м*) болон хувийн өмчийг (*борлуулах, дуудлага худалдаа зохион байгуулах г.м*) улсын болон орон нутгийн захиргаанд шилжүүлдэг байна.

3.Шүүхийн барилга байгууламжийн аюулгүй байдлаар сайн туршлагыг хэрэгжүүлснээр шүүхийн байранд террорист халдлага болон гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлж чадсан нь ололттой.

4.АНУ-ын дүүргийн шүүгч Эстер Салас[16] 2022 онд “Даниел Андерлийн шүүхийн аюулгүй байдал, хувийн нууцын тухай” хуулийг төслийг санаачлан боловсруулж, Сенатад батлуулсан. Энэ хууль нь шүүхүүдийн цахим орчинд аюул заналхийллийг хянах, хариу арга хэмжээ авах чадварыг сайжруулж, шүүгчдийн аюулгүй байдлын сайн туршлага болсон нь сайн талтай.

5.НУМА-ны хамгаалалтад шүүхийн байр, шүүгч төдийгүй шүүгчийн хувийн амьдрал, гэр бүл, гэрч, хохирогч, шүүн таслах ажиллагааны оролцогч нарыг хамруулан хамгаалах, урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих, стратегийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, хөгжүүлж үйл ажиллагаандаа нэвтрүүлдгээрээ онцлог давуу талтай.

2.2.АВСТРАЛИЙН ХОЛБООНЫ УЛС

Австралийн Холбооны Улс (АХУ) нь Үндсэн хуульт хаант засагтай, парламентын холбооны улс юм. Тус улсын төрийн тэргүүн нь Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын хаан III Чарльз бөгөөд бүрэн эрхийг нь түүний өргөмжилсөн Амбан захирагч хэрэгжүүлдэг. [17] Засаг захиргааны хувьд 6 муж (Шинэ Өмнөд Вэльс, Квинсланд, Өмнөд Австрали, Тасмани, Виктория, Баруун Австрали), 2 том эх газар, бусад жижиг арлаас бүрддэг байна.

АХУ-ын шүүх эрх мэдлийн дээд байгууллага нь Холбооны дээд шүүх бөгөөд шүүхийн тогтолцоо нь холбооны шүүх, мужийн шүүх, тусгай шүүхүүдээс бүрдэнэ.

Эрх зүйн орчин

[15] *https://www.usmarshals.gov/what-we-do/witness-security*

[16] *АНУ-ын дүүргийн шүүгч Эсрер Саласыг интернэтээр мөшгөж, шүүх хуралд оролцож байсан сэжигтэн этгээд хүү Даниел Андерлийн амь насыг хохироосон. Халдлагад нөхөр нь хүнд шархадсан. Шүүгчийн хувийн мэдээллийг цахим орчноос хялбар олдох боломжийг энэхүү хуулиар хязгаарласан юм байна.*

[17] АХУ-ын Үндсэн хуулийн 65.

АХУ-д “Шүүхийн аюулгүй байдлын тухай хууль”[18] (2013), Шүүхийн аюулгүй байдлын тухай хуулийн тайлбар[19] (2023), Шүүхийн аюулгүй байдлын журам[20](2023)-аар шүүхийн аюулгүй байдлын асуудлыг зохицуулж байна. Харин шүүгчийн аюулгүй байдлыг хангах асуудлыг “Австралийн төрийн албан хаагчийн аюулгүй байдлын протокол”-ын хүрээнд зохицуулдаг.[21]

Шүүхийн аюулгүй байдлын тухай хуулиар Австралийн Дээд шүүх, Австралийн Холбооны шүүх, Австралийн Холбооны тойрог ба Гэр бүлийн шүүх, Баруун Австралийн Гэр бүлийн шүүх, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхүүдийн барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах, дэг журам сахиулах, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах ажиллагааг хуульчилсан байна.

Шүүхийн аюулгүй байдал

Шүүхийн аюулгүй байдлын тухай хуульд зааснаар шүүхийн байр гэдэгт:

1. бүх шатны шүүхийн байр;
2. шүүхийн архив, баримт бичиг хадгалагдаж буй байр;
3. шүүн таслах үйл ажиллагаа явуулахаар түр болон удаан хугацаагаар шүүх байрлаж буй аливаа байр;
4. шүүх хуралдааныг зайнаас цахим хэлбэрээр явуулахаар бэлтгэсэн байр;
5. шүүхийн барилга байгууламжийн авто зогсоол, автозамыг хамааруулдаг байна.

Шүүхийн аюулгүй байдлын тухай хуулиар шүүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах ба үүнд шүүгч, шүүхийн ажилтнуудын ажилдаа ирэх, очих үеийн аюулгүй байдлыг хангах асуудлыг хамааруулжээ. Мөн шүүхийн аюулгүй байдлын ажилтан, албан хаагчийг томилох асуудлыг хуульчилсан байна. Шүүхийн захиргааны байгууллагын тэргүүн нь шүүхийн эрх бүхий ажилтан, шүүхийн аюулгүй байдлын ажилтныг томилдог.

Шүүхийн аюулгүй байдлын ажилтан, албан хаагч нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- шүүхийн байранд шүүхийн ажилтнууд, иргэдийн нэвтрэх хөдөлгөөнд хяналт тавих, үзлэг хийх;
- шүүхийн байранд нэвтрэх иргэдийн биеийн байцаалт, холбогдох баримт бичгийг шалгаж оруулахдаа тэсэрч дэлбэрэх болон хорт бодис, зэвсгийн чанартай эд зүйлс байгаа эсэхэд хяналт тавьж хураан авах;
- сэжигтэй этгээд, согтууруулах болон мансууруулах бодис хэрэглэсэн этгээдийг шүүх хуралдаанд оруулахгүй, шүүхээр үйлчлүүлэхгүй байх арга хэмжээ авах;
- шүүхийн ажилтнууд, байранд нэвтэрч буй иргэдэд аюулгүй байдлын зааварчилгаа өгөх;

[18] Court Security Act 2013, Australia https://www.legislation.gov.au/Details/C2013A00128
[19] Court Security Regulations 2023, Explanatory statement https://classic.austlii.edu.au/
[20] Court Security Regulations 2023 https://www8.austlii.edu.au/
[21] The Australian Government Personnel Security Protocol, 2014

- Шүүн хуралдааны журам сахиулах, шүүх хуралдааны журам зөрчсөн этгээдийн зөрчлийг таслан зогсоох;
- Шүүхийн байранд нэвтрүүлэхээс татгалзах, хориглох, шүүхийн байрнаас гаргах, албадан гаргахаар хүч хэрэглэх зэрэг болно. Дээрх шаардлагыг биелүүлээгүй бол 20 нэгжээр торгууль ногдуулдаг байна.

Шүүхийн аюулгүй байдлын ажилтан, эрх бүхий шүүхийн ажилтан дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхдээ сургалтад хамрагдан тусгай зөвшөөрөл авсан байна. Мөн эдгээр ажилтнуудад тавигдах шаардлага, эрх мэдлээ хаана хэрэгжүүлэх, ажилтнуудын үйл ажиллагаатай холбоотой гомдлыг шийдвэрлэх механизмыг Шүүхийн аюулгүй байдлын журамд тусгайлан заасан байна.

Шүүгчийн аюулгүй байдал

АХУ-д шүүгчийн аюулгүй байдлыг хангах асуудлыг “Австралийн төрийн албан хаагчийн аюулгүй байдлын протокол”-ын хүрээнд зохицуулдаг.[22] Энэ протоколоор шүүгчийг гэмт халдлагаас хамгаалахтай холбоотой бодлого, журмыг зохицуулж байна. Шаардлагатай тохиолдолд шүүгчийн гэр бүлийн гишүүд, бусад этгээдийг хамгаалалтад авдаг. Мөн шүүхийн байрнаас гадуур шүүгчийг хамгаалахтай холбоотой бүхий л шаардлагатай арга хэмжээг авахаар тусгасан.[23] Гэхдээ тус протоколоор аюулгүй байдлын арга хэмжээ нь ямар байх талаар зохицуулаагүй буюу энэ талын мэдээлэл оруулаагүй байна.

2.3.ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

Шүүх хуралдааны үеэр ноцтой зөрчил, эсэргүүцэл их гардгаас үүдэн ХБНГУ-д шүүгчдийн аюулгүй байдлыг хангахад маш их анхаардаг. Улс төрийн гэмт хэргүүд дээр ажиллаж байгаа шүүгчид ажил үүргээ гүйцэтгэж байхдаа заналхийлэлд байнга өртдөг байна. Германы шүүгчдийн холбооноос 2020 онд эрхлэн гаргасан судалгаанд “нийт шүүгчдийн 6 хувь нь ажил үүргээ гүйцэтгэж байхдаа халдлага, заналхийлэлд өртдөг” гэсэн дүнг гаргаж байсан бөгөөд үүнээс үүдэн шүүхийн барилгын хамгаалалтыг нэмэгдүүлэх, олон нийтийн анхаарлыг татсан гэмт хэрэг дээр ажиллаж байгаа шүүгчийг биечилсэн хамгаалалтад авах зэрэг арга хэмжээг зохион байгуулахад чухал нөлөө үзүүлсэн.

ХБНГУ нь хүчирхийллийг хориглож, шударга ёсыг тогтоосон хууль, эрх зүйн орчинтой бөгөөд хууль тогтоомжоороо шүүгчийн хараат бус байдлыг хангаж, шударгаар ажил үүргээ гүйцэтгэх боломжийг бүрдүүлсэн байдаг. Шүүгчийн хараат бус байдал, аюулгүй байдлыг хангах нь тухайн шүүгчид хууль ёсны, шударга шийдвэр гаргахад амин чухал гэдгийг сүүлийн жилүүдийн судалгаанаас харуулж байна.

ХБНГУ-ын шүүгчдэд тулгардаг заналхийлэл янз бүр бүр байдаг. Шүүхийн шийдвэрт сэтгэл хангалуун бус байгаа, санал нийлэхгүй байгаа шүүгдэгч талуудаас шүүгчид айлган сүрдүүлэлт, хүчирхийлэл үзүүлдэг байна. ХБНГУ-ын шүүгчдийн холбооноос гаргасан судалгаагаар нийт шүүгчдийн 30 гаруй хувь нь ажил үүргээ гүйцэтгэх хугацаанд айлган сүрдүүлэлт, заналхийлэл, хүчирхийлэлд өртдөг байна.

[22] The Australian Government Personnel Security Protocol, 2014
[23] Шүүхийн аюулгүй байдлыг хангах бүтэц, цаашид түүнийг бэхжүүлэх арга зам, 2016

Сүүлийн жилүүдэд шүүгчдийн талаар худал хуурмаг мэдээллийг цахим орчинд түгээх, тухайн шүүгчийг цахим орчинд доромжлох, заналхийлэх байдал ихэссэн нь шүүгчдийн сэтгэл зүйн байдалд ихээхэн нөлөөлж байна. Ихэнх тохиолдолд эдгээр заналхийлэл, доромжлол нь улс төрийн гэмт хэрэг дээр ажиллаж байгаа шүүгчдэд тохиолддог байна.

Шүүгчийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудлыг ХБНГУ нь хэд хэдэн хуулиар зохицуулж, хэд хэдэн байгууллага шүүгч, шүүхийн аюулгүй байдлыг хангахаар ажиллаж байна.

BBC News-ийн мэдээлснээр 2016 оноос хойш 25 гаруй шүүгч зохион байгуулалттай гэмт хэрэгтэй холбоотойгоор шууд заналхийллийн улмаас нэмэлт хамгаалалт хүссэн байгаа нь шүүгчийн аюулгүй байдал хэр хэмжээнд харж болохоор байна.

Нөгөө талаас шүүгчийн сэтгэл зүйн байдалд хийсэн судалгаанаас харахад аюул заналхийлэл, хүчирхийлэлд өртсөн шүүгчдийн сэтгэл зүйн байдал нь түгшүүртэй, айдастай, үүнээс үүдэн архаг ядаргаанд орсон байдаг байна. Ийм учраас заналхийлэлд өртсөн шүүгчдэд сэтгэл зүйн, цаашлаад сэтгэцийн эрүүл мэндийн дэмжлэг авах шаардлагатай гэсэн дүгнэлт гаргасан байна.

Шүүгчийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой эрх зүйн зохицуулалт

ХБНГУ холбооны шүүхийн системтэй. ХБНГУ-ын Үндсэн хуулийн 95 дугаар зүйлд “Холбооны улс нь иргэний болон эрүүгийн, захиргааны, санхүүгийн, хөдөлмөрийн болон нийгмийн хамгааллын дагнасан шүүхүүдийн дээд байгууллага болох Холбооны улсын дээд шүүхийг болон Холбооны улсын хөдөлмөрийн шүүх, Холбооны улсын санхүүгийн шүүх, Холбооны улсын хөдөлмөрийн шүүх болон Холбооны улсын нийгмийн хамгааллыг шүүхийг тус тус байгуулсан байна” гэж заасан байдаг.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 106б дугаар зүйл. Хууль тогтоох байгууллагын үйл ажиллагаанд саад учруулах, тасалдуулах

1) Холбооны эсвэл муж улсын Хууль тогтоох байгууллагын барилга, түүний ойр орчмын нутаг дэвсгэрт аюулгүй байдал, дэг журамтай холбоотой зөрчил гаргасан, үйл ажиллагаанд нь саад учруулах, үйл ажиллагааг тасалдуулах үйлдэл гаргасан тохиолдолд нэг жилээс дээш хугацаагаар эсвэл торгох ял оногдуулна.

Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйл. Хууль сахиулах байгууллагын албан хаагчдын хамгаалах

1) Хууль сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийг заналхийлэх, сүрдүүлбэл гурваас илүүгүй жилээр хорих эсвэл торгууль оногдуулна.
2) Заналхийлэл, сүрдүүлэг нь хүнд хэлбэрийн байвал 6 сараас 5 жил хүртэлх хугацаагаар хорих ял оногдуулна. Хүнд хэлбэрийн заналхийлэл, сүрдүүлэгт дараах үйлдлүүд орно:

a. Тухайн гэмт хэрэгтэн биедээ зэвсэг болон аюултай зүйл авч явсан тохиолдолд,
b. Гэмт этгээдийн учруулсан хүчирхийлэл, заналхийлэл нь амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулсан тохиолдолд,
c. Гэмт хэргийг өөр этгээдтэй хамтран үйлдсэн тохиолдолд.

Эрүүгийн хуулийн 114 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албан тушаалтан халдлагад өртөх

1) Хууль сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэж байх үед халдах, заналхийлэх, сүрдүүлэх үйлдэл гаргавал 3 сараас 5 жил хүртэлх хугацаагаар хорих ял оногдуулна.
2) Энэ хуулийн 113 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг дагаж мөрдөнө.

Эрүүгийн хуулийн 115 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албан тушаалтантай дүйцэхүйц албан тушаалтанд халдах

1) Энэ хуулийн 113, 114 дүгээр зүйлд заасан хууль сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх цагдаагийн алба хаагч, прокурорын мөрдөн байцаагчийг хамгаалахад хамаарна.
2) Хууль сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэхэд туслах үүрэгтэй оролцож байгаа алба хаагчийг хамгаалахад энэ хуулийн 113, 114 дүгээр зүйл мөн хамаарна.

Шүүхийн барилгын аюулгүй байдал

Шүүхийн барилгын аюулгүй байдалд тавигдах шаардлагуудад дараах зүйлс заавал байх ёстой. Үүнд:

2012 онд Дахау (Dachau) дүүргийн шүүхэд шүүгдэгч этгээд шүүх хурлын үеэр улсын яллагчийг буудаж, амь насыг нь хохироосон гэмт хэрэг гарч байсан. Энэ хэргээс үүдэн бусад муж улсын шүүхийн байгууллагуудыг шүүхийн аюулгүй байдалд илүү анхаарах шаардлага гарсан байна. 2017 оны эхээр Берлин хотын шүүхийн байгууллага энэ асуудлыг хууль, эрх зүйн хүрээнээс гадна шүүхийн байгууллагын тогтолцооны бүх салбарт аюулгүй байдалтай холбоотой бүх асуудлыг цогцоор нь авч үзэх шаардлагатай гэж дүгнэж тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр сүүлийн жилүүдэд Берлиний шүүхийн хамгаалалт сайжирсан үр дүн гарсан байна.

Шүүх эрх мэдлийн бүхий л салбарт хамаарах аюулгүй байдлын тогтолцооны үзэл баримтлалыг бий болгохын тулд зохих мэргэжилтний мэдлэг шаардлагатай гэдэг нь тодорхой байсан тул Берлин мужийн Хууль зүйн захиргаа аюулгүй байдлын тогтолцооны үзэл баримтлалыг боловсруулах өргөн хүрээний төслийг эхлүүлсэн. Энэхүү төслийн хүрээнд Берлиний шүүхийн бүх салбарын 40 гаруй ажилтан долоон ажлын хэсэгт хуваагдан уг төсөл дээр ажилласан. Уг төслийн хүрээнд бусад мужуудын одоо байгаа аюулгүй байдлын үзэл баримтлалыг үнэлж, аюулгүй байдлын хүрээний үзэл баримтлалд оруулах шаардлагатай нэмэлт сэдвүүдийг тодорхойлсон. Энэ төслийн хүрээнд шүүхийн барилга байгууламжид хийсэн үнэлгээ, шинжилгээний дүнд бүх шатны шүүхийн байгууллагуудад дараах арга хэмжээг авснаар шүүхийн барилгын аюулгүй байдлыг хангах бүрэн боломжтой гэсэн дүгнэлт гарсан байна. Уг дүгнэлтэд:

1) Бүх шатны шүүхийн барилгуудад дохиоллын систем, дохиоллын системийг хянах төвүүд байх зайлшгүй шаардлагатай бөгөөд шүүхийн барилгын гол хаалганы хэсэгт нэвтрэх хэсэг, шалган нэвтрүүлэх хяналтын төхөөрөмж, шүүхийн байранд нэвтэрсэн иргэдийн эд зүйлсийг хадгалах сав гэх мэт шаардлагатай бүх зүйлсийг шүүхийн байршуулах шаардлагатай бөгөөд хамгийн чухал нь шүүгч, шүүхийн байгууллагын алба хаагч, иргэдийн орц гарцыг тусад нь байлгах шаардлагатай. Түүнчлэн шүүхийн байгууллагын бүх хаалга маш нарийн хамгаалагдсан цоожтой байх ба бүх хаалганууд нь сум нэвтэрдэггүй байх шаардлагатай.
2) Шүүхийн барилгын гэрэлтүүлэг, агаар солилцох системийг гаднаас нэвтрэхээс хамгаалсан байх. Түүнчлэн шуудангийн хайрцгийг тусад нь зохицуулснаар гаднаас зөвшөөрөлгүй нэвтрэх, халдлагад өртөхөөс сэргийлнэ.
3) Шүүхийн барилгыг нийтийн эзэмшлээс зам, талбайгаас аль болох хол байлгах, 2.50 метрээс дээш өндөртэй хашаагаар тусгаарлах тухайн барилгын 1, 2 дугаар давхрыг халдлагад өртөхөөс хамгаалах боломжийг бүрдүүлснээр шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хамгаалах, хангах боломжтой гэж үзсэн байна.

Шүүхийн байгууллагын аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллага

ХБНГУ-ын шүүхийн аюулгүй байдлыг хангах үүргийг хэд хэдэн байгууллагууд хүлээсэн байдаг. Тухайлбал, шүүх, цагдаа, шүүхийн аюулгүй байдлын тусгай ажилтнууд гэх мэт. Дээр дурдсанчлан ХБНГУ-ын муж улс бүр шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг өөрсдийн хууль, эрх зүйн орчны хүрээнд хангаж ажилладаг.

Тухайн муж улсын цагдаагийн байгууллага шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй бөгөөд шүүгдэгчдийн зүгээс ирэх заналхийлэл, сүрдүүлэг даамжирсан тохиолдолд нэмэлт хүч авах, олон нийтийн анхаарлын төвд байгаа гэмт хэргийн шүүх хурлын үеэр бэлэн байдалд байх, хамгаалалтыг чангатгах гэх мэт арга хэмжээг авч ажилладаг байна. Үүнээс гадна шүүхийн аюулгүй байдлыг хангах ажилтнууд байдаг. Эдгээр ажилтнууд нь шүүхийн дэг сахиулах, шүүхийн барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах, яаралтай тусламж үзүүлэх гэх мэт үүргийг хүлээн ажилладаг байна.

Цагдаагийн байгууллага шүүгч, прокурор, гэрч, хохирогч, өмгөөлөгч, шүүгдэгчийн аюулгүй байдлыг нь хамгаалах үүрэгтэй ба шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хамгаалахад дараах 3 гол арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Үүнд:

- Шүүхийн байранд нэвтэрч буй иргэдэд хяналт тавих: иргэдийн баримт бичгийг шалгах, эд зүйлс (биедээ авч яваа зүйлсийг хяналтын төхөөрөмжөөр шалгах), шүүхийн байрны орц, гарцыг хянах;
- Шүүхийн барилгын ойр орчимд суурилуулсан хяналтын камеруудыг хянах, сэжигтэй үйлдэл гаргахаас урьдчилан сэргийлэх;
- Шүүх хурлын өмнө, дараа болон шүүх хурлын үеэр эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, хэрэв шүүх хуралд оролцогчдын үйлдэл хурцадмал байдалд хүрэх, олон нийтийн анхаарлын төвд байгаа гэмт хэргийн шүүх хурлын үеэр шаардлагатай гэж үзвэл нэмэлт хүч дуудах, шаардлагатай арга хэмжээг авах бэлэн байдалд байх гол 3 үүрэгтэй ажилладаг.

ГУРАВ.МОНГОЛ УЛСЫН ШҮҮХ, ШҮҮГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТОГТОЛЦОО, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Товч түүх

1924, 1940, 1960 оны Үндсэн Хуулиудаар байгуулагдаж байсан “Шүүн таслах газар”, “Шүүх таслах газар”, “Ардын шүүх”-д тухайн үеийн цагдан сэргийлэх байгууллага шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах, хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлж ирсэн.[24]

1992 оны ардчилсан, шинэ Үндсэн Хуулийн дагуу Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч шүүхүүдийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг цагдаагийн байгууллага гүйцэтгэж байсан. 2013 онд Монгол Улсын Их Хурлаас Тахарын албаны тухай хуулийн баталж, Тахарын ерөнхий газрыг байгуулан шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг цагдаагийн байгууллагаас тус байгууллагад шилжүүлсэн байдаг. Тахарын алба 2013 оноос 2016 он хүртэл ажиллаж байгаад татан буугдсан бөгөөд чиг үүргийг нь цагдаагийн албанд буцаан шилжүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор Тахарын албыг татан буулгаж, Тахарын ерөнхий газрын даргын 2016 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн Б/247 дугаар тушаалаар алба хаагчдыг чөлөөлж, Цагдаагийн байгууллагын мэдэлд шилжүүлсэн. Энэхүү бүтэц зохион байгуулалттай холбогдуулан ЦЕГ-ын даргын 2016 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн Б/437 дугаар тушаалаар Цагдаагийн ерөнхий газрын даргын тус газрын бүтцэд “Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэлтэс”-ийг байгуулж, Нийслэлийн хэмжээнд Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэлтсийг төвийн 6 дүүргийг хариуцуулан 93 албан хаагчийн орон тоотойгоор, аймгуудын цагдаагийн газрын нийтийн хэв журам хамгаалах тасгийн бүтцэд нөхцөл байдалд уялдуулан орон тоог тогтоож, томилон ажиллуулж эхэлсэн.

2022 оны байдлаар Цагдаагийн байгууллагаас шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр нийт 280 гаруй албан хаагч ажиллаж байна. Тэдгээр албан хаагчид:

- Шүүхийн байрны хамгаалалт,
- Шүүх хуралдааны дэг сахиулах,
- шүүгч, шүүх бүрэлдэхүүн, хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах
- Шүүгдэгч, яллагдагчийг хуяглан хүргэх үйл ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Монгол Улсын шүүхийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ыг баталж, 2021 оны 03 сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Уг хуульд шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой шинэлэг зохицуулалтууд нэмэгдсэн нь шүүгч, түүний гэр бүлийн гишүүний аюулгүй байдлыг хангах ажиллагааг шинээр зохицуулсан юм.[25]

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.4-д “Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндэд аюул занал учрах нөхцөл үүссэн тухай мэдээлэл авсан бол цагдаагийн байгууллага энэ байдлыг таслан зогсооход чиглэсэн арга хэмжээг даруй авах үүрэгтэй” 49.5-д “Энэ хуулийн 49.4-т заасан арга хэмжээг авах нөхцөл, журмыг Ерөнхий зөвлөлийн дарга, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн

[24] Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, цаашид анхаарах асуудал, Цагдаагийн хурандаа Н.Лхагвасайхан, Шүүх эрх мэдэл сэтгүүл 2022 оны (№01) тусгай дугаар, 27 дахь тал

[25] Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх асуудал, Х.Билгүнзаяа (LL.M)), Шүүх эрх мэдэл сэтгүүл 2022 оны (№01) тусгай дугаар, 19 дэх тал

газрын гишүүн хамтран батална.” гэж заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/301, 186 дугаартай хамтарсан тушаалаар “Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндэд аюул занал учрах нөхцөл үүссэн үед хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх журам”-ыг шинээр баталсан.
Өмнө нь шүүгч, шүүх бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх асуудлыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаалаар баталсан “Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам”-аар зохицуулж байсан. Тус журмаар шүүгч, шүүх бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын арга хэмжээг “биечлэн дагах” байдлаар хэрэгжүүлдэг байсан бол шинээр батлагдсан журмаар хамгаалах субъектийг өргөжүүлж, хамгаалалтын арга хэмжээний төрлийг 9 болгон нэмэгдүүлсэн байна.

Эрх зүйн орчин

- Монгол Улсын Үндсэн Хууль (1992)
- Монгол Улсын Шүүхийн тухай хууль (2021)
- “Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндэд аюул занал учрах нөхцөл үүссэн үед хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх журам” ШЕЗ-ийн дарга, ХЗДХ-ийн сайдын хамтарсан тушаал 2021.12.28-ны өдрийн А/301, 186 дугаар тушаал
- “Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх, тэмдэглэл үйлдэх, шийдвэрлэх журам” ШЕЗ-ийн 2021.09.28-ны өдрийн 49 дугаар тогтоол
- “Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам” ШЕЗ-ийн дарга, ХЗДХ-ийн сайдын хамтарсан тушаал, 2021.05.20-ны өдрийн А/116/65
- “Шүүгчийн бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх, хадгалах заавар” ШЕЗ-ийн даргын 2014.01.29-ны өдрийн 11 дүгээр тушаал
- “Биечилсэн хамгаалалтын журам” Хууль зүйн сайдын 2014.11.14-ны өдрийн А/204 дугаар тушаал

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хамгаалалтын арга хэмжээ

Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхдээ шүүгчийн халдашгүй байх эрхэд сөргөөр нөлөөлсөн, нөлөөлж болохуйц үйл ажиллагаа явуулахгүй байх, хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, эрүүл мэнд, аюулгүй байдалд харшлах байх, нууцлалын нөхцөл, шуурхай байдал, хууль сахиулах байгууллага, төрийн байгууллага, төрийн болон иргэний нийгмийн байгууллага, иргэдтэй харилцахдаа саад учруулахгүй, аюулгүй байдлыг хангасан байх, гэрээ, төлөвлөгөөтэй байх шаардлага, нөхцөлийг хангаж ажиллах бөгөөд хамгаалалтыг төрийн тусгай хамгаалалт, зэвсэгт хүчин, бусад цэрэг, тагнуул, харуул хамгаалалтын бүсэд хэрэгжүүлж болно. Шүүх байранд аюулгүй байдлыг хянахад учирч болох эрсдэлүүд нь нэлээд өндөр бөгөөд олон янз байдалтай, тэдгээр нь хэзээ ч бүрэн үгүйсгэгддэггүй тул байнгын урьдчилан сэргийлэх болон хяналтад байх арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.

Цагдаагийн байгууллага нь шүүх, шүүхийн барилга байгууламжийн аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:[26]

1. шүүхийн барилга байгууламжийн аюулгүй байдал, хамгаалалтыг хариуцах, шүүхийн байранд иргэдийг нэвтрүүлэх хөдөлгөөнд нь хяналт тавих үүрэг бүхий шүүхийн байрны харуулын цагдааг томилон, үйл ажиллагаанд нь өдөр тутмын хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар хангах;
2. шүүх, шүүхийн барилга байгууламжийг 24 цагаар харуул хамгаалалтад байхаар зохион байгуулж, харуулын цагдаагийн ажиллах дэг горимыг тогтоох;
3. шүүхийн харуулын цагдаагийн өдөр тутмын ажил хүлээлцэх, тусгай хэрэгсэл, эд зүйл хүлээлцэх, үүрэг гүйцэтгэлийн байдалд байнгын хяналт тавьж ажиллах;
4. шүүхийн харуулын цагдаагаас хууль тогтоомж, энэ журамд заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгэхийг шаардах, дотоод хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг шалгах, арилгах арга хэмжээг зохион байгуулах;
5. шүүх хуралдааныг шүүхийн байрнаас бусад газар хийх болон “Сахилгын хороо”-ны хуралдаанд шүүгч оролцох үеийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг шүүхийн тамгын газартай хамтран зохион байгуулах;
6. ажлын ачаалал үүссэн тохиолдолд шүүхийн харуулын цагдааг нэмж томилох, нэмэлт хүч авах;
7. шүүх болон түүний гадна орчинд олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, гэнэтийн халдлага гарах, шүүгч, гэрч, хохирогчийн амь биед халдах, барьцаалах, шүүхийн байр руу дайрах, бүслэх, үйл ажиллагааг тасалдуулахыг оролдох, галдан шатаах, шүүхийн байрны орчимд замын хөдөлгөөн хаах зэрэг иргэд, байгууллагын зүгээс учруулж буй аливаа хууль бус үйлдлийн улмаас шүүхийн шүүн таслах ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх боломжгүй, мөн үйл ажиллагаанд нь саад учруулсан буюу учруулахаар оролдсон онцгой нөхцөл үүссэн тохиолдолд учрах эрсдэл, аюулыг зайлуулах, түүний хохирлыг багасгах талаар шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх, шүүхийн байрыг хүч нэмэгдүүлсэн хамгаалалтад авах;
8. шүүхийн тамгын газартай хамтарч ажиллах чиглэлээр харилцан санал солилцож, хариу мэдэгдэх;

Цагдаагийн байгууллага нь хамгаалалтад авсан шүүгч, түүний гэр бүлийн гишүүний ажлын байр, гудамж талбай, орон байр, олон нийтийн газар зэрэг учирч болох аюул, эрсдэлийг тооцож мэдэгдэх, урьдчилан сэргийлэх, хамгаалалтын арга хэмжээний дэг горимыг мөрдөх сургалт явуулах ба хамгаалалтад байгаа шүүгчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор шүүхийн тамгын газарт санал гаргаж, шүүхэд нэвтрэх ажилтнуудын картын нууцлалыг тухай бүр солих шүүгч, шүүхийн ажилтны өрөө, шүүхийн барилга байгууламжид нэвтрэх, гарах хэсэг, эвлэрүүлэн зуучлах хэсэг, авто машины ил, далд зогсоол, цахилгаан шат, ажлын байрны болон орон байрны хонгил, уулзалтын өрөө зэргийг хамгаалалтын дохиолол, дуу-дүрс бичлэгийн техник, хэрэгслийн хяналтад авах зэрэг шаардлагатай ажлыг зохион байгуулна.

Шүүгч, түүний гэр бүлийн гишүүнд дараах төрлийн хамгаалалтын арга хэмжээ авдаг. Үүнд:

- Урьдчилан сануулах:
- Тодорхой үйлдлийг хязгаарлах:

[26] “Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам” ШЕЗ-ийн дарга, ХЗДХ-ийн сайдын хамтарсан тушаал, 2021.05.20-ны өдрийн А/116/65

- Биечилсэн хамгаалалт:
- Мэдээллийн нууцлалыг хангах:
- Хувийн хамгаалалтын хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах:
- Аюулгүй газарт түр байршуулах:
- Нүүлгэн шилжүүлэх:
- Баримт бичгийг солих:
- Гадаад төрхийг өөрчлөх:
- Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ:

Тулгамдсан асуудал

- Өнөөдрийн байдлаар шүүх, шүүхийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр цагдаагийн байгууллагын хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь Тахарын албатай харьцуулахад хамгаалалтын арга хэрэгсэл, хүч нөөц, арга механизмын хувьд харьцангуй сул байгааг шүүгч, шүүхийн байгууллагын ажилтнууд онцлон дурдаж байна.[27] Тахарын алба нь шүүх, шүүхийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр илүү дагнаж, зохион байгуулагдсан тусгайлсан чиг үүргийг хариуцаж байснаараа онцлог юм. Монгол Улсад Тахарын алба байгуулагдах болсон үндэслэлүүдийн нэг нь тухайн үед буюу 2008 оны 07 сарын 01-ний үймээнээр Цагдаагийн байгууллагын удирдлага хүч, галт зэвсэг хэрэглэсний улмаас 5 хүний амь нас хохирсон хэргийг Шүүх хуралдааны үед аюулгүй байдлыг хангах үүрэгтэй цагдаагийн албан хаагчид үйлдэл, эс үйлдлээр бодит эрсдэл учруулж байсан явдал юм.
- Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах өөрийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд ч санхүү, хүн хүчний хомсдолтой байдаг учраас шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хүч хэрэгслээ бүрэн дүүрэн дайчлах боломж хомс байдаг.
- Сүүлийн үеийн авлига, албан тушаалын гэмт хэргийн нөхцөл байдал, төр, төрийн албан хаагчдад хандах нийгмийн сэтгэл зүйн огцом уналтын улмаас шүүгчийн амь нас, эрүүл мэндэд заналхийлсэн халдлага өсөн нэмэгдэж байна. Энэ халдлага гол төлөв шүүхийн барилга дотор, эсхүл шүүхийн барилгын орчим, шүүх хуралдааны үед мөн шүүгч, шүүхийн барилга руу нэвтрэх, барилгаас гарах үед үйлдэгддэг байна.
- Түүнчлэн олон нийтийн цахим сүлжээнд шүүгчийн аюулгүй байдлыг хангах, элдэв гүтгэлэг, доромжлол, сүрдүүлэг, заналхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх асуудал хурцаар тавигдаж байна.

[27] Шүүгчийн аюулгүй байдал. УДШ-ийн ЗХТ-ийн шүүгч Ц.Цогт (LL.D) Шүүх эрх мэдэл сэтгүүл 2022 оны (№01) тусгай дугаар, 8, 12 дахь тал

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Австрали

- АХУ-ын Үндсэн хууль
- Court Security Act 2013, Australia
- Court Security Regulations 2023, Explanatory statement
- The Australian Government Personnel Security Protocol, 2014
- ‘’Шүүхийн аюулгүй байдлыг хангах бүтэц, цаашид түүнийг бэхжүүлэх арга зам’’ Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судалгааны тайлангийн эмхэтгэл 2016

АНУ

- Federal Judicial Center annual report, 2023 https://www.fjc.gov/sites/default/files/materials/10/FJC-Annual-Report-2023.pdf
- Guide to Judiciary Policy, Code of Conduct for Judicial Employees
- https://www.uscourts.gov/sites/default/files/guide-vol02a-ch03-2.pdf
- Enhancing Efforts to Coordinate Best Workplace Practices Across the Federal Judiciary https://www.fjc.gov/sites/default/files/materials/56/NAPA_FJC%20final%200701_0718.pdf
- Judicial Conference Approves Measures to Increase Security for Federal Judges, 2020 https://www.uscourts.gov/news/2020/08/14/judicial-conference-approves-measures-increase-security-federal-judges
- Judiciary Affirms need for Bill to Protect Federl Judges.2021 https://www.uscourts.gov/news/2021/07/14/judiciary-affirms-need-bill-protect-federal-judges
- Judiciary seeks new Judgeships, Reaffirms need for Enhanced Security, 2021 https://www.uscourts.gov/news/2021/03/16/judiciary-seeks-new-judgeships-reaffirms-need-enhanced-security
- U.S. Judicial Conference Urges Senate to back Security Funding,2021 https://www.uscourts.gov/news/2021/06/09/us-judicial-conference-urges-senate-back-security-funding
- Judicial Security Resources Stretched Amid Rising Threats, 2024 https://news.bloomberglaw.com/us-law-week/judicial-security-resources-stretched-amid-rising-threats
- Judicial Security, 2014 survey report https://www.ncjfcj.org/wp-content/uploads/2022/03/USMS_judicilal-security-survey_report.pdf
- Rule of Law https://www.uscourts.gov/educational-resources/educational-activities/rule-law
- Judicial Security, Facilities and Security- annual report, 2022 https://www.uscourts.gov/statistics-reports/facilities-and-security-annual-report-2022
- U.S. Marshals Service, Judicial Security https://www.usmarshals.gov/what-we-do/judicial-security

- АНУ-ын Маршалын албаны засгийн газрын веб хаяг https://www.usmarshals.gov/sites/default/files/media/document/PUB-1-2020-Strategic%20Plan.pdf
- Confidentiality regulations for Pretial Services Information https://www.uscourts.gov/rules-policies/judiciary-policies/confidentiality-regulations-pretrial-services-information
- Steps to Best Practices for Court building security. revised June 2022 https://www.ncsc.org/__data/assets/pdf_file/0032/78647/Best-Practices-for-Court-Building-Security.pdf
- U.S. Marshals Service. Withness Security
- https://www.usmarshals.gov/what-we-do/witness-security
- Audit of the U.S.Marshals Service Judicial Security Activities.2021 https://oig.justice.gov/sites/default/files/reports/21-083.pdf

Герман

- Шүүхийн байр, шүүгчийн аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээний аргачлалын талаарх судалгаа: гадаад улсын сайн туршлага
- Judiciary at a glance in Germany, https://rm.coe.int/germany-2021-data-/1680ab89b8
- ХБНГУ-ын Эрүүгийн хууль, https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html
- Холбооны Үндсэн хуулийн шүүх, https://www.bundesverfassungsgericht.de/DE/Homepage/homepage_node.html
- ХБНГУ-ын Үндсэн хууль, https://www.gesetze-im-internet.de/englisch_gg/englisch_gg.html
- Берлиний шүүхийн аюулгүй байдлын үзэл баримтлал, https://www.drb-berlin.de/themen-und-positionen/justizthemen/justizthema/news/sicherheitsrahmenkonzept-der-berliner-justiz

Монгол Улс

- Монгол Улсын Үндсэн Хууль:
- Монгол Улсын Шүүхийн тухай хууль:
- “Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндэд аюул занал учрах нөхцөл үүссэн үед хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх журам” ШЕЗ-ийн дарга, ХЗДХ-ийн сайдын хамтарсан тушаал 2021.12.28-ны өдрийн А/301, 116 дугаар тушаал
- “Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх, тэмдэглэл үйлдэх, шийдвэрлэх журам” ШЕЗ-ийн 2021.09.28-ны өдрийн 49 дугаар тогтоол
- “Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам” ШЕЗ-ийн дарга, ХЗДХ-ийн сайдын хамтарсан тушаал, 2021.05.20-ны өдрийн А/116/65
- “Шүүгчийн бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх, хадгалах заавар” ШЕЗ-ийн даргын 2014.01.29-ны өдрийн 11 дүгээр тушаал
- Шүүхийн аюулгүй байдлыг хангах бүтэц, түүнийг цаашид бэхжүүлэх арга зам. ШСМСХ-ийн судлаач Л.Галбаатар, ахлах референт Э.Өлзийлхам (PhD),

Судалгааны тайлангийн эмхэтгэл, Шүүхийн судалгаа мэдээлэл, сургалтын хүрээлэн 2016

- Шүүхийн байр, шүүгчийн аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээний аргачлалын талаарх судалгаа: гадаад улсын сайн туршлага, ШСМСХ-ийн судлаач Ч.Содхүү 2016
- Шүүгчийн аюулгүй байдал, Ц.Цогт (LL.D), Шүүх эрх мэдэл сэтгүүл 2022 оны (№01) тусгай дугаар
- Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх асуудал, Х.Билгүнзаяа (LL.M)), Шүүх эрх мэдэл сэтгүүл 2022 оны (№01) тусгай дугаар
- Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, цаашид анхаарах асуудал, Цагдаагийн хурандаа Н.Лхагвасайхан, Шүүх эрх мэдэл сэтгүүл 2022 оны (№01) тусгай дугаар

---oOo---